

АЯНГА-Х | ЭНГИЙН ТЭСРЭХ БОДИС

Хэрэглээ

Энэ бүтээгдэхүүн нь сүвэрхэг мөхлөгт Аммиакийн шүү, дизель түлш болон бусад шатах нэмэгдлүүдээс бүрдэх тэсрэх бодис юм. Энэ тэсрэх бодисыг хатуулаг өндөртэй чулуулаг бүхий ил болон далд уурхайд хуурай буюу усгүйжүүлсэн цооног, шпурт үндсэн цэнэг болгон ашиглах бөгөөд өдөөгчийн тусламжтайгаар тэсэлнэ.

Онцлог шинж чанар

Задгай байдалдаа усанд тэсвэргүй, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, ашиглалтын явцад харьцангуй аюул багатай, хамгийн хямд, үйлдвэрлэлийн тэсэлгээнд нэн тохиромжтой учир дэлхийн улс орнуудын уулын үйлдвэрлэлд өргөн хэрэглэгдэж байна.

Сав баглаа боодол

“Аянга-Х” бүтээгдэхүүнийг дизель түлш, чийгний нэвчилтээс хамгаалсан полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлан, мөн нойтон, чийгтэй, устай цооногт хэрэглэх зорилгоор ус чийг үл нэвчээх давхар уутанд 76, 101, 127 мм-ийн голчтойгоор олгойлон савлан үйлдвэрлэж байна.

Бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт

Монгол Улсын Үндэсний MNS 4223-94 стандартын шаардлагыг бүрэн хангасан болно.

Хадгалалт

Хуурай болон агааржуулалт сайтай агуулахад 2 сар хадгална.

Гарал үүсэл

Монгол улс, “Мера” ХХК, Т11 үйлдвэр НҮБ-ын дугаар: 0331, ангилал: 1.5D .



ШИНЖ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шинж чанар	Үзүүлэлтүүд
Овоолгын нягт	0.8-0.9 г/см ³
Цэнэглэлтийн нягт	1.0-1.2 г/см ³
Тэсрэлтийн дулаан	4000 кдж/кг
Тэсрэлтийн хийн эзэлхүүн	965 м ³ /кг
Хүчилтөрөгчийн тэнцэл	+0.28 %
Детонацийн хурд	3500 м/с
Ажлын чадвар	320-360см ³
Туйлын диаметр	120-160 мм
Дэгдэмхий бодисын хэмжээ, ихгүй	1.5%

МЭДРЭХ ЧАДВАР

а. бялт тэслүүр	мэдрэмжгүй
б. гал дамжуулах шижим	мэдрэмжгүй